



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөргөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/013/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2026 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Н.Ариунтуяа

Утас: 94004399

Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1 Төлбөрийн акт	10
3.2 Зөвлөмж.....	10
3.2.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал	10
3.2.2 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал.....	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.25 № 079

танай _____ -ны № _____ -т

ДӨРГӨН СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Б.ЦЭДЭН - ИШ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дөргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Дөргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.5, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16.5.1, 16.5.2, 16.5.4, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43.3, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны 86 дугаар тушаал орон нутгийн хөгжлийн сангийн журмын 3.4, 9.8 дах заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа ажлуудад урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй байхад урьдчилгаа төлбөр

8476110691

олгосон, хөрөнгө оруулалтын ажлуудыг дуусаагүй байхад 62,564.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон,

- Цаг агаарт зориудаар нөлөөлөх генераторын түлшийг гэрээ байгуулан худалдан авсан ч данс бүртгэлд тусгаагүй зарцуулалт тодорхойгүй 11,184.0 мянган төгрөг,
- Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлуудыг хүлээн авах ажлын хэсэг хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, дуусаагүй ажлыг хүлээн авсан, явцын хяналт хэрэгжүүлээгүй нийт 60,077.0 мянган төгрөг зарцуулсан,
- Чадварлаг багш, худгийн засварын ажлаас суутгасан ХХОАТ-г тайлагнаагүй, өглөг авлагаар бүртгээгүй 2,295.0 мянган төгрөг,
- Насжилт өндөртэй өглөгийг барагдуулаагүй 851.6 мянган төгрөгийн зэрэг зөрчлүүд байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Дөргөн сум нь 2025 оны байдлаар 2,859 хүн амтай, 138 төрийн албан хаагчтай, 773 өрхтэй, 442 малчин өрхтэй, 130 мал бүхий өрх, малчинтай, жилийн эцсийн мал тооллогоор 179,530 толгой мал тоолуулжээ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Дөргөн сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 767,708.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 105,238.4 мянган төгрөг буюу 115.9 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татсан асуудлыг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тусгасан болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,073,552.17	933,479.54
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	699,989.2	442,957.56
3	1.1.3 АВЛАГА	152,883.25	231,904.69
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	157,708.98	191,061.66
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	62,970.73	67,555.63
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,734,649.09	4,820,336.3
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,734,649.09	4,820,336.3
8	1.2.2.02 Биет хөрөнгө	2,700,558.33	4,681,368.1
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	34,090.76	138,968.2
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	3,808,201.26	5,753,815.84
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	23,858.79	60,800.41
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23,858.79	60,800.41
13	2.1.1.03 Өглөг	23,858.79	60,800.41
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,784,342.47	5,693,015.44
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	3,784,342.47	5,693,015.44
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	795,806.14	795,806.14
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	2,807,566.99	4,729,439.86
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	180,969.33	167,769.44
19	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	3,808,201.26	5,753,815.84

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,806,869.22	4,741,979.88
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	758,455.14	767,708.00
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	677,500.6	694,234.07
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	698,257.32	717,252.82
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20,756.72	-23,018.75
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	57,652.04	48,562.21
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	23,302.5	24,911.72
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	367,044.76	3,974,271.88
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,140,617.51
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,681,369.32	0.0

11	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,414,478.65	2,804,188.9
12	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,414,478.65	2,804,188.9
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,381,645.63	2,703,992.9
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	731,413.47	893,003.43
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,665.94	107,577.61
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	589,585.52	615,107.56
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	577,387.63	685,908.52
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,200	0.0
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	11,147.46	10,216.1
20	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	8,668	9,524
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,814.46	33,717.25
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	337,763.15	348,938.43
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	32,833.02	100,196.00
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	392,390.57	1,937,790.98
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	24,384.98	0.0
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-24,384.98	0.0
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	368,005.59	1,937,790.98

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,545,776.32	2,416,879.61
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	758,455.14	767,708
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	677,500.6	694,234.07
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20,756.72	-23,018.75
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	57,652.04	48,562.21
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	23,302.5	24,911.72
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,201.49	2,909.16
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	16,902.01	19,922.07
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,199	2,080.5
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,951.85	1,649,171.61
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	105,951.85	44,770.2
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,140,617.51
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	463,783.9
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,681,369.32	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,658,162.94	1,896,343.25

16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,658,162.94	1,896,343.25
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,624,789.92	1,796,147.25
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	732,261.5	892,902.5
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,560.6	111,336.13
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	589,585.52	617,197.56
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	38,786.8	30,741.32
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,697.6	0.0
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	10,704.76	11,152.15
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	10,115.5	9,524
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,225.59	39,355.97
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	111,852.04	83,937.63
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,373.02	100,196
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	887,613.38	520,536.36
29	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	634,492.12	677,418
30	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	634,492.12	677,418
31	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	634,492.12	677,418
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-634,492.12	-677,418
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,100.00	100,150.00
34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-3,100.00	-100,150.00
35	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	250,021.26	-257,031.64
36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	449,967.94	699,989.2
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	699,989.2	442,957.56

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,425,696.48	3,425,696.48
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-8,159.89	-8,159.89
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,417,536.58	3,417,536.58

4	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,199.7	-1,199.7
5	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	368,005.59	368,005.59
6	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,784,342.47	3,784,342.47
7	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,784,342.47	3,784,342.47
8	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-15,918.11	-15,918.11
9	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,768,424.36	3,768,424.36
10	1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-13,199.9	-13,199.9
11	1.7 Тайлант үеийн үр дүн	1,937,790.98	1,937,790.98
12	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,693,015.44	5,693,015.44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мянган төгрөгөөр

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,341,197.50	2,386,100.90
11	3.1.01.1.1 Татварын орлого	662,469.70	767,707.99
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	562,307.20	694,234.06
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	585,325.90	717,252.81
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(23,018.70)	(23,018.74)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	71,170.00	48,562.21
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	28,992.50	24,911.72
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,500.00	2,909.16
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	21,392.50	19,922.06
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,100.00	2,080.49
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,678,727.80	1,618,392.90
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	105,105.00	44,770.20
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,109,838.80	1,109,838.80
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	463,784.00	463,783.90
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,778,705.00	2,650,817.54
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,906,672.90	1,873,249.54
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,904,723.90	1,773,053.54
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	925,185.80	892,902.49
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,648.30	111,336.12
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	634,246.60	617,197.56
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	38,527.40	29,945.81
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	683.20	-
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	12,951.00	11,152.15
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	10,554.20	9,524.00
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,543.20	37,902.75
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	118,384.20	63,092.63
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,949.00	100,196.00
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00

2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	1,949.00	1,000.00
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	770,532.10	677,417.99
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	101,500.00	100,150.00
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	437,507.50	264,716.63
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	699,989.19
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	435,272.55

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	2024.12.31	2025.12.31
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	67,784.54	30,778.70
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,784.54	30,778.70
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	67,784.54	30,778.70
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	67,784.54	30,778.70
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	67,784.54	30,778.70
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	67,784.54	458,875.62
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	67,784.54	297,787.62
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,748.24	283,412.62
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	13,051.60	480.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,909.64	1,812.447
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	25,837.00	281,120.17
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,754.98	14,375.00
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	8,754.98	14,375.00
22	1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	161,088.00
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	-	161,088.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	17,281.32	18,495.097

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ТТЗ-ын нэгтгэл хамруулан гүйцэтгэсэн ТТЗ-ын нэгтгэл, ОНХС, ХХС-гийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 254,829.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 117,458.2 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд:

- Санхүүгийн байдлын тайланг зөрүүтэй илэрхийлсэн – 29,043.8 мянган төгрөг,

Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд:

- Санхүү байдлын тайлан, үр дүнгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн – 88,414.4 мянган төгрөг,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил,

¹ Мэдээллийг тусгахагүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 31,377.3 мянган төгрөгөөс их, шинж чанарын хувьд материаллаг байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 137,371.6 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 400.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 136,971.6 мянган төгрөгийн 6 зөрчилд зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаас төлөөлөгчдийг чадавхжуулах хөтөлбөрөөс сургалтын төлбөрийг 16 хүнээр тооцон шилжүүлсэн байхад 14 төлөөлөгч оролцсон сургалтын төлбөрийг 400.0 мянган төгрөгөөр илүү тооцон шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 -д ” Гүйлгээ, үйл ажиллагааг үнэн зөв бүртгэх”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоосон.

3.2 Зөвлөмж

3.2.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй насжилт өндөртэй 851.6 мянган төгрөгийн өглөгийг барагдуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16 дугаар зүйлийн 16.5.4-д “үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх үүрэгтэй” гэж заасантай, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Насжилт өндөртэй өглөгийг барагдуулах үе шаттай арга хэмжээ авч ажиллах.

3.2.2 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

3.2.2.1 Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа ажлуудад урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй байхад урьдчилгаа төлбөр олгосон, хөрөнгө оруулалтын ажлуудыг дуусаагүй байхад 62,564.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ТБОНӨХБАУХТХ-ийн 43.3-д “Урьдчилгаа төлбөрийн баталгаа

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно” гэж заасантай, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй байхад урьдчилгаа санхүүжилт олгохгүй байх.

3.2.2.2 Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн цаг агаарт зориудаар нөлөөлөх генераторын түлшийг гэрээ байгуулан худалдан авсан ч данс бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-т "бүх орлого" гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Генераторын түлшийг бараа материалын орлогод бүртгэж зарцуулалтын тайланг гаргаж ажиллах.

3.2.2.3 Илрүүлэлт: Чадварлаг багш, Худгийн засварын ажлаас суутгасан ХХОАТ-г тайлагнаагүй, өглөг, авлагаар бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: ХХОАТ-н тайланг нөхөн тайлагнах.

3.2.2.4 Илрүүлэлт: Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлуудыг хүлээн авах ажлын хэсэг хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, дуусаагүй ажлыг хүлээн авсан, явцын хяналт хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны 86 дугаар тушаал орон нутгийн хөгжлийн сангийн журмын 3.4, 9.8 заалтуудыг зөрчиж хөрөнгө оруулалтын ажилд хяналт хэрэгжүүлээгүй." гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжид заасны дагуу хяналтыг хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлын чанарт анхаарах.

3.2.2.5 Илрүүлэлт: Засаг даргын тамгын газрын нэр дээр бүртгэлтэй бохирын машин, ковш, усны машин, халуун усны байрын түрээсийн гэрээг шинэчлэн зах зээлийн ханшийг баримтлан өөрийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрэн ашиглаагүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" ИТХ-ын тогтоолыг нэмж тусгана. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т сумын өмчийн ашиглалт, эзэмшилт, захиран зарцуулалт, түүнд тавих хяналт" гэж заасантай нийцээгүй, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх хөрөнгүүдийн түрээсийн гэрээг шинэчлэн зах зээлийн ханшийг баримтлан өөрийн орлогыг нэмэгдүүлэн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга

хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Хоршоо хөгжүүлэх сан	Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүү, алдангийг зөрүүтэй тооцон илэрхийлсэн	1	29,043.80			1	29,043.80	1	29,043.8				
Орон нутгийн хөгжлийн сан	Урьдчилж гарсан зардал болон байгууллагад төлөх өглөг зөрүүтэй илэрхийлсэн.	1	88,414.4	1	88,414.4			1	88,414.4				
		2	117,458.20	1	88,414.4	1	29,043.80	2	117,458.2				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Орон нутгийн хөгжлийн сан	Төлөөлөгчдийг чадавхижуулах хөтөлбөрөөс сургалтын төлбөрийг 16 хүнээр тооцон шилжүүлсэн байхад 14 төлөөлөгч оролцсон	1	400.0	1	400.0							
Орон нутгийн хөгжлийн сан	ОНХС-н хөрөнгөөр бэлтгэсэн цаг агаарт шуудаар нөлөөлөх генераторын түлшийг гэрээ байгуулан худалдан авсан ч данс бүртгэлд тусгаагүй	1	11,184.0					1	11,184.0			

Орон нутгийн хөгжлийн сан	ОНХС-н хөрөнгөөр гүйцэтгэж байгаа ажлуудад урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй байхад урьдчилгаа төлбөр олгосон, ажлуудыг дуусаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон	1	62,564.0					1	62,564.00		
Орон нутгийн хөгжлийн сан	Чадварлаг багш, Худагны засварын ажлаас суутгасан ХХОАТ-г тайлагнаагүй, өглөг, авлагаар бүртгээгүй	1	2,295.0					1	2,295.00		
Орон нутгийн хөгжлийн сан	Төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажлуудыг хүлээн авах ажлын хэсэг хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, дуусаагүй ажлыг хүлээн авсан, явцын хяналт хэрэгжүүлээгүй.	1	60,077.0					1	60,077.00		
Хоршоо хөгжүүлэх сан	Насжилт өндөртэй өглөгийг барагдуулаагүй	1	851.6					1	851.60		
ТТЗ	ЗДТГазрын нэр дээр бүртгэлтэй бохирын машин, ковш, усны машин, халуун усны байрын түрээсийн гэрээг шинэчлэн зах зээлийн ханшийг баримтлан өөрийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрэн ашиглаагүй	1	-					1	-		
дүн		7	137,371.6	1	400.0	0	-	6	136,971.60	0	-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				

A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1				1		